



МОНГОЛ УЛСЫН
ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

210646 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Бага тойруу, Засгийн газрын IV байр,
Утас: 26-04-37, Факс: 32-32-66

ТӨРИЙН ӨМЧИЙН ХОРООНЫ
ДАРГА Д.ЦОГТБААТАР ТАНАА

2012.05.24 № 06/НГ УАГ-СНГ/2013/НГ/04-743

Хөрөнгө бүртгэх тухай

Хөдөлмөрийн яамны харьяа БНСУ дахь Нэг цэгийн үйлчилгээний төвийн 2012 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

ХХҮГ-ын/хуучнаар/ харьяа БНСУ дахь Төлөөгчийн газрын үндсэн хөрөнгийг Хөдөлмөрийн яаманд шилжүүлсэн тухай ТӨХ-ны шийдвэр гаргаагүй учир уг 40.4 сая төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хөрөнгийг бүртгэж санхүүгийн тайланд тусгаагүй байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11.2-д “ТӨХ төрийн өмчийн эд хөрөнгийн анхан шатны бүртгэл, тооллого, тайлан тэнцэл гаргах ажлыг зохион байгуулж удирдах, төрийн өмчийн эд хөрөнгийн ашиглалтад хяналт тавьж, түүний үр ашгийг дээшлүүлэх арга хэмжээ авах эрхтэй” гэж заасныг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 15.1.12-д “аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2009 оны 47 дугаар тушаалаар баталсан “Төлбөрийн акт тавих, албан шаардлага өгөхөд баримтлах журам”-ыг үндэслэн ШААРДАХ НЬ:

1. Дээрх үндсэн хөрөнгийг Хөдөлмөрийн яаманд шилжүүлэх асуудлыг шийдвэрлэхийг ТӨХ-ны дарга Д.Цогтбаатарт хариуцуулав.

Албан шаардлагын биелэлтийг 2013 оны 12 дугаар сарын 25-ны дотор багтаан Үндэсний аудитын газарт ирүүлэхийг мэдэгдье.

АЛБАН ШААРДЛАГА ХҮРГҮҮЛСЭН:

АУДИТОР Д.ГАНДОЛГОР

УХА0122